



ҮНДЭСНИЙ
СТАТИСТИКИЙН
ХОРОО

БИЕЙН ТАМИР, СПОРТ - 2020



Улаанбаатар хот

2021 он

БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН САЛБАР

Танилцуулгыг хянасан:

А.Амарбал ҮСХ-ны Нийгмийн статистикийн газрын дарга
С.Тодгэрэл ҮСХ-ны Нийгмийн статистикийн газрын Нийгмийн статистикийн хэлтсийн дарга
Н.Должинсүрэн ҮСХ-ны Нийгмийн статистикийн газрын Нийгмийн статистикийн хэлтсийн ахлах статистикч

Танилцуулгыг боловсруулсан:

М.Доржпагма ҮСХ-ны Нийгмийн статистикийн газрын Нийгмийн статистикийн хэлтсийн статистикч
Цахим шуудангийн хаяг: dorjpaqam@nso.mn

Хаяг:

Засгийн газрын III байр, Бага тойруу -44, Улаанбаатар -11 Монгол Улс

Цахим хаяг: www.nso.mn, www.1212.mn

Цахим шуудангийн хаяг: information@nso.mn

Утас: 51-263966

АГУУЛГА

ОЙЛГОЛТ ТОДОРХОЙЛОЛТ

ОРШИЛ

БҮЛЭГ 1. БИЕЙН ТАМИР, СПОРТЫН БАЙГУУЛЛАГА	6
БҮЛЭГ 2. СПОРТЫН БАРИЛГА, БАЙГУУЛАМЖ	8
БҮЛЭГ 3. ТАМИРЧИД, ШҮҮГЧИД.....	10
БҮЛЭГ 4. ҮНДЭСНИЙ СПОРТ	13

ДҮГНЭЛТ

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Биеийн тамир, спортын байгууллагын тоо, оноор	7
Зураг 2. Биеийн тамир, спортын байгууллагад ажиллагчдын тоо, хүйс, оноор	7
Зураг 3. Биеийн тамир, спортын байгууллагад ажиллагчид, албан тушаалын төрөл, хувиар, 2020 он.....	8
Зураг 4. Спорт заалны тоо, оноор	8
Зураг 5. Шинээр ашиглалтад орсон спортын гадаа талбай, төрөл, дүнд эзлэх хувиар, 2020 9	
Зураг 6. Шинээр ашиглалтад орсон спортын барилга, байгууламж, дүнд эзлэх хувиар, 2020	9
Зураг 7. Цол, зэрэгтэй тамирчид, дасгалжуулагчид, шүүгчдын тоо, хүйс, оноор	11
Зураг 8. Олон улсын шүүгчийн тоо, оноор	11
Зураг 9. Шинээр спортын цол авсан тамирчид, төрөл, дүнд эзлэх хувиар, 2020 он	12
Зураг 10. Олон улсын мастер цолтой тамирчдын тоо, оноор.....	12
Зураг 11. Улсын шүүгчдийн тоо, оноор.....	12
Зураг 12. Биеийн тамир, спортоор хичээллэгчдийн тоо, оноор	13
Зураг 13. Биеийн тамир, спортоор хичээллэгчид, бүс, дүнд эзлэх хувиар, 2020 он	14

Зураг 14. Шинээр улсын цол авсан бөхчүүд, цолны төрөл, дүнд эзлэх хувиар, 2020 он.....	13
--	----

Зураг 15. Цолтой бөхчүүд, цолны төрөл, оноор	13
--	----

ХАВСРАЛТ ХҮСНЭГТ

Хүснэгт 1. Биеийн тамир, спортын байгууллагад ажиллагчид, бүс, аймаг, нийслэлээр	16
Хүснэгт 2. Биеийн тамир, спортын байгууллага, бүс, аймаг, нийслэлээр.....	17
Хүснэгт 3. Биеийн тамир, спортоор хичээллэдэг тамирчид, бүс, аймаг, нийслэлээр.....	18
Хүснэгт 4. Спорт заал, бүс, аймаг, нийслэлээр	19
Хүснэгт 5. Цолтой тамирчид, дасгалжуулагчид, шүүгчид, бүс, аймаг, нийслэлээр.....	20

ОЙЛГОЛТ ТОДОРХОЙЛОЛТ

Биеийн тамир¹ гэж хүн амын идэвхтэй хөдөлгөөнөөр хичээллэх, эрүүл мэндийг дэмжихэд чиглэсэн үйл ажиллагаа юм.

Спорт¹ гэж хүний оюун ухааны болон бие, бялдрын хөгжлийг дэмжсэн идэвхтэй үйлдлийг ойлгоно.

Тамирчин¹ гэж спортын сургалт-дасгалжуулалтаар бэлтгэгдэн, спортын тэмцээнд оролцдог этгээд юм.

Дасгалжуулагч¹ гэж спортын сургалт-дасгалжуулалт, спортын тэмцээнд оролцуулах үйл ажиллагааг удирдаж байгаа этгээд юм.

Спортын барилга, байгууламж¹ гэж спортоор хичээллэх, спортын тэмцээн зохион байгуулах зориулалт бүхий байгууламж, түүний дэд бүтэц юм.

Спорт заал, гадаа талбай гэдэгт биеийн тамир, спортоор хичээллэгч, тамирчин, дасгалжуулагчийн идэвхтэй хөдөлгөөн, бэлтгэл, сургуулилт хийх талбайн стандарт, техник, эрүүл ахуйн шаардлагыг хангасан байгууламж, заал, талбайг хамруулна.

Спортын арга хэмжээ гэдэгт спортын бүх төрлөөр хичээллэх, бэлтгэл хийх, тэмцээн уралдаан зохион байгуулах болон спортын бусад арга хэмжээг хамруулж ойлгоно.

- Спортын тэмцээн¹ гэдэгт тогтоосон дүрмийн дагуу өрсөлдөх үйл явцыг ойлгоно.
- Спортын наадам¹ гэдэгт нэгдсэн хэлбэрээр зохион байгуулж байгаа спортын тэмцээн, соёл урлагийн арга хэмжээний нэгдлийг ойлгоно.

Үндэсний спорт¹ гэж ард түмний уламжлал, зан заншилд тулгуурлан хөгжсөн үндэсний онцлог шинжийг агуулсан спорт юм.

¹Монгол Улсын "Биеийн тамир, спортын тухай" хуулийн 4 дүгээр зүйл

ОРШИЛ

БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ҮҮСЭЛ ХӨГЖИЛ

Биеийн тамир, спорт нь нэн эрт үеэс өнөөг хүртэл хүн төрөлхтний оршин тогтносон бүх цаг хугацааны туршид бие бялдрыг хөгжүүлж, амьдралд хэрэгтэй зайлшгүй шаардлагатай хөдөлгөөний чадвар, дадлыг эзэмшүүлэх гол хэрэглүүр болж ирсэн бөгөөд нийгмийн ерөнхий соёлын салшгүй нэг хэсэг болсон юм. Аливаа улс гүрэн оршин тогтнох гол үндэс нь эрүүл чийрэг бие бялдартай ард түмэн билээ. Түүхэн хөгжлийн урт удаан хугацаанд хүн төрөлхтөний амьдралын хүрээнд өдөр тутам хэрэглэгддэг энгийн дасгал, хөдөлгөөн, тоглоомын үйлдлүүдээс орчин үеийн биеийн тамир, спортын төрлүүд бий болж олон улсын хэмжээнд спорт, олимпийн хөдөлгөөн болтол хөгжлийн замыг туулсан. Орчин үеийн нийгэмд олон улсын спортын хөдөлгөөн нь улс гүрнүүдийн харилцан ойлголцох эв найрамдал, нөхөрлөлийг бэхжүүлэх эдийн засаг, соёл шинжлэх ухааны ололт амжилтыг илтгэн харуулах хүчин зүйл болж, нэр цуутай тамирчдаараа бахархан эх орноо дэлхий нийтэд сурталчлах арга хэрэгсэл болсон билээ.

Монгол Улсын соёлын түүхийн нэг хэсэгт биеийн тамир, спортын хөгжлийн түүх зүй ёсоор багтдаг. Манай орны биеийн тамир, спортын хөгжлийн түүх нь хүний нийгэм үүссэн цагаас эхлэн газар нутаг, цаг агаар, хүн ам, зан заншил, ахуй нөхцөл зэргийг нийгмийн амьдралын бусад талуудтай харилцан холбоотойгоор хөгжиж иржээ.

Нийт ажиллагчид
783

Хөгжлийн бэрхшээлтэй
11


317

Захиргаа,
санхүүгийн
ажилтан
84

Удирдах
ажилтан
56

Биеийн
тамирын арга
зүйч
62



10
Эмч

201
Дасгалжуулагч

294
Үйлчилгээ, аж
ахуйн ажилтан



79
Мэргэжилтэн




42
Бусад

БҮЛЭГ 1. БИЕЙН ТАМИР, СПОРТЫН БАЙГУУЛЛАГА


Улсын хэмжээнд 2020 оны байдлаар биеийн тамир, спортын 32 байгууллагад, 839 хүн ажиллаж байна. Ажиллагчдын тоо өмнөх оноос 102 (13.8%)-оор нэмэгдсэн байна. Нийт ажиллагчдын 62.2 хувь нь эрэгтэйчүүд байна.

ЗУРАГ 1. БИЕЙН ТАМИР, СПОРТЫН БАЙГУУЛЛАГЫН ТОО, оноор



Нийт ажиллагчид болон байгууллагын тоо өмнөх оноос өссөн гол шалтгаан нь Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 47 дугаар тогтоолоор Монгол Улсын Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээнд Засгийн газрын тохируулагч агентлаг-Биеийн тамир, спортын улсын хороог байгуулах тушаалаар Биеийн тамир, спортын улсын хороог байгуулсантай холбоотой юм.

Зураг 2. Биеийн тамир, спортын байгууллагад ажиллагчдын тоо, хүйс, оноор



Биеийн тамир, спортын байгууллагад ажиллагчдын тоо 2017 оны байдлаар 5.1 мянга болж бусад онуудтой харьцуулахад өндөр байгаа нь тухайн онд Биеийн тамир, спортын нэг удаагийн үзлэг, тооллого явагдаж биеийн тамир, спортын үйл ажиллагаа эрхэлдэг байгууллагад ажилладаг нийт ажиллагчдын тоогоор мэдээлсэн болно.

Зураг 3. Биеийн тамир, спортын байгууллагад ажиллагчид, албан тушаалын төрөл, хувиар, 2020 он




Нийт ажиллагчдыг албан тушаалын төрлөөр харвал 294 (35.0%) нь үйлчилгээ, аж ахуйн ажилтан, 201 (24.0%) нь дасгалжуулагч, 84 (10.0%) нь захиргаа санхүүгийн ажилтан, 79 (9.4%) нь мэргэжилтэн, 62 (7.4%) нь биеийн тамирын арга зүйч, 56 (6.7%) нь удирдах ажилтан, 42 (5.0%) нь бусад, 10 (1.2%) нь эмч мэргэжилтэн байна.

БҮЛЭГ 1. СПОРТЫН БАРИЛГА, БАЙГУУЛАМЖ


2020 оны байдлаар Улсын хэмжээнд нийт 856 спортын гадаа талбай байна. Үүний 69 (8.1%) нь 2020 онд шинээр ашиглалтад орсон байна. Ашиглалтад орсон барилга байгууламжыг төрлөөр нь харвал 50 (72.5%) нь спортын гадаа талбай, 5 (7.2%) нь гүйлтийн зам, 5 (7.2%) нь явган алхалт, аяллын зам, 4 (5.8%) нь наадмын талбай, 3 (4.3%) дугуйн зам, 1 (2.9%) нь бусад байгууламж байна.

Зураг 4. Спорт заалны тоо, оноор




Улсын хэмжээнд 2020 оны байдлаар 1065 спортын зориулалттай заал байна. Энэ онд шинээр 49 спорт заал ашиглалтад орсон бөгөөд 12 (24.5%) нь Баруун бүсэд, 11 (22.4%) нь Төвийн бүсэд, 11 (22.4%) нь Нийслэлд, 10 (20.5%) нь Хангайн бүсэд, 5 (10.2%) нь Зүүн бүсэд байна.


Зураг 5. Шинээр ашиглалтад орсон спортын гадаа талбай, төрөл, дүнд эзлэх хувиар, 2020 он



2020 онд Монгол Улсын хэмжээнд 64 спортын барилга, байгууламж ашиглалтад орсон бөгөөд үүний 49 (76.6%) нь спортын заал, 4 (6.3%) нь усан бассейн, 4 (6.3%) нь бэлтгэлийн заал, 4 (6.3%) нь спортын ордон, 3 (4.7%) нь бусад байгууламж байна.

Зураг 6. Шинээр ашиглалтад орсон спортын барилга, байгууламж, дүнд эзлэх хувиар, 2020 он





Year 2020

БИЕИЙН ТАМИР, СПОРТООР ХИЧЭЭЛЛЭГЧИД



Зохион байгуулсан арга
хэмжээ

1 132


Зохион байгуулсан арга
хэмжээнд хамрагдагчид

193 666

БҮЛЭГ 2. ТАМИРЧИД, ШҮҮГЧИД


Монгол Улсын хэмжээнд 2020 онд 1327 тамирчин спортын цол авсан нь өмнөх онтой харьцуулахад 624 (32.0%)-өөр буурсан байна. 2020 онд шинээр цол авсан тамирчдын 383 (28.9%) нь эмэгтэй тамирчид байна. Цол авсан тамирчдыг цолны төрлөөр харвал 144 (10.8%) нь олон улсын хэмжээний мастер, 700 (52.8%) нь спортын мастер, 483 (36.4%) нь дэд мастер цолтой тамирчид байна.

Зураг 7. Цол, зэрэгтэй тамирчид, дасгалжуулагчид, шүүгчдын тоо, хүйс, оноор




Спортын цол, зэрэгтэй тамирчид, дасгалжуулагчид, шүүгчид 2020 оны байдлаар 31.4 мянга байгаа бөгөөд 9.9 (31.6%) мянга нь эмэгтэйчүүд байна. Өмнөх оноос цол, зэрэгтэй тамирчид, дасгалжуулагчид, шүүгчид 1668 (5.6%)-аар нэмэгдсэн байна.

Зураг 8. Олон улсын шүүгчийн тоо, оноор




2020 онд нийт 130 олон улсын шүүгч байна. Өмнөх оноос 5 (0.4%)-аар нэмэгдсэн байна.

Зураг 9. Шинээр спортын цол авсан тамирчид, төрөл, дүнд эзлэх хувиар, 2020 он




Олон улсын масер цолтой тамирчин 2017 онд явагдсан нэг удаагын үзлэг тооллогын дүнгээр 566 байсан бол 2020 оны байдлаар 1304 болж 2.3 дахин нэмэгдсэн байна. Олон улсын цолтой тамирчдын тоо жил ирэх тусам нэмэгдэж байгаа нь манай улсын тамирчдын ур чадвар улам бүр нэмэгдэж, олон улсад үнэлэгдэн нэр алдараа мандуулж буй нэгэн илрэл билээ.

Зураг 10. Олон улсын мастер цолтой тамирчдын тоо, оноор



Эн онд шинээр цол авсан 70 шүүгчийн 13 (18.6%) нь эмэгтэй, 5 (7.1%) нь олон улсын шүүгч, 65 (92.9%) нь улсын шүүгч байна.

Зураг 11. Улсын шүүгчдийн тоо, оноор



БҮЛЭГ 3. ҮНДЭСНИЙ СПОРТ

Монгол Улсын соёлын өвийн нэг болох ард түмний эрийн гурван наадам нь манай спортын түүхэн эхлэл гэж үздэг. Монголчууд эрт үеэс наадам хийсэн түүхтэй ч яг хэдий үеэс эхэлж, хийх болсон тухай тодорхой баримт одоогоор олдоогүй байна. Түүхийн хуудсыг сөхвөл монголчууд үр хүүхэд, хойч үеэ хурд хүч, авхаалж самбаа, бяр чадалтай нэгэн болгохын тулд багаас нь хөдөлгөөнт тоглоомоор чийрэгжүүлж, хөлөгт тоглоомоор оюун санааг нь хөгжүүлж ирснээрээ дэлхийн соёлд их хувь нэмэр оруулсан байдаг. Биеийн тамир спортыг хөгжүүлэхэд ардын үндэсний хэлбэртэй тоглоом наадгайгаас сонгон түүнийг түшиглэн бусад төрлийн наадам, тоглоомыг дэлгэрүүлэн хэрэглэж, манай үндэсний соёлд тэр дундаа биеийн тамир спортын цаашдын хөгжилд чухал суурь болж иржээ. Манай оронд ардын засаг төрийг тунхаглан зарласан 1921 оноос эхлэн эрт үеийн уламжлалт ардын спорт, эрийн гурван наадам болон ард түмний дотор түгэн дэлгэрсэн хөлөгт болон хөдөлгөөнт тоглоомд үндэслэн шинэ цагийн биеийн тамирын төрөл бүрийн спортыг хөгжүүлж Монгол хүний бие бялдрыг чийрэгжүүлэх ажлыг бусад салбартай уялдуулан явуулж иржээ.

Шинээр цол авсан 207 бөхчүүдийн 12 (5.8%) нь улсын цолтой, 54 (26.1%) нь аймаг, цэргийн цолтой, 141 (68.1%) нь сумын цолтой бөхчүүд байна. 2020 онд 134 харваач, 523 уяачид шинээр цол авсан байна.

Зураг 12. Шинээр улсын цол авсан бөхчүүд, цолны төрөл, дүнд эзлэх хувиар, 2020 он



Улсын хэмжээнд 2020 оны байдлаар 5652 цолтой бөхчүүд байгаагийн 3923 (69.4%) нь сумын цолтой, 1432 (25.3%) нь аймаг, цэргийн цолтой, 297 (5.3%) нь улсын цолтой бөхчүүд байна. Цолтой бөхчүүдийн тоог өмнөх онтой харьцуулахад 207 (3.8%) -гоор нэмэгдэж, улсын цолтой бөхчүүд 12 (4.2%) -оор, аймаг, цэргийн цолтой бөхчүүд 54 (3.9%) -өөр, сумын цолтой бөхчүүд 141 (3.7%) -ээр нэмэгдсэн байна.

Зураг 13. Цолтой бөхчүүд, цолны төрөл, оноор



ДҮГНЭЛТ

Монгол Улсын хэмжээнд 2020 оны байдлаар биеийн тамир, спортын 32 байгууллагад, 839 ажиллагчид ажиллаж байгаагаас 317 (37.8%) нь эмэгтэйчүүд байна. Улсын хэмжээнд 2020 онд 49 спорт заал шинээр ашиглалтад орж нийт 1065 болж өмнөх оноос 49 (4.8%)-өөр нэмэгдсэн байна. Улсын хэмжээнд 1668 тамирчид дасгалжуулагчид шинээр цол авсан ба 383 (23.0%) эмэгтэй, 144 (8.6%) олон улсын мастер, 700 (42.0%) спортын мастер, 483 (29.0%) спортын дэд мастер, 134 (8.0%) цолтой сурын харваачид, 207 (12.4%) цолтой бөхчүүд байна. Мөн шинээр олон улсын шүүгч цол авсан 5, улсын шүүгч цолтой 65 шүүгч байна. Биеийн тамир, спортын салбарын ажиллагчдыг 2020 оныг 2016 онтой харьцуулахад 250 (50.1%)-аар, спорт заалны тоо 215 (25.3%)-аар тус тус нэмэгджээ.

Дэлхий нийтэд хотжилт, техник, технологийн хөгжил хурдацтай явагдаж, суурин иргэншил давамгайлан, хүн амын амьдралын хэв маяг өөрчлөгдсөнтэй холбоотой улс орнууд биеийн тамир, спортыг дэмжих замаар хүний дундаж наслалтыг уртасгах, хүнээ хөгжүүлэхэд анхаарлаа хандуулж байна. Монгол Улсын хүн амын 67 хувь нь хот, суурин газарт амьдарч, 35 хүртэлх насны хүүхэд, залуучууд 64 хувийг эзэлж байна. Улсын хөгжлийг даган хүн амын амьдралын хэв маяг болон хөдөлмөр эрхлэлт, соёл иргэншилд гарч байгаа өөрчлөлт нь хүний идэвхтэй хөдөлгөөнийг хязгаарлах, хөдөлгөөний хомсдолтой холбоотой өвчлөл, эндэгдэл нэмэгдэхэд хүргэж байна. Энэ бүхнийг харгалзан биеийн тамир, спортыг олон хувилбартай, сонголт хийх боломжоор ханган хөгжүүлж, хувь хүн, хамт олон, байгууллагын түвшинд хэвшүүлэх шаардлагатай байна.

Монгол Улсын Их Хурлаас 2009 онд Биеийн тамир, спортыг хөгжүүлэх талаар төрөөс баримтлах бодлогыг баталсан боловч хууль, эрх зүйн зохицуулалт тодорхойгүй байснаас хэрэгжүүлэхэд хүндрэлтэй байсан

Монгол Улсын Их Хурлаас 2017 онд баталсан Биеийн тамир, спортын тухай хуулиар төрийн зарим чиг үүргийг спортын мэргэжлийн холбоод, клубээр гэрээгээр гүйцэтгүүлэх эрх зүйн зохицуулалт тодорхой болж, цаашид бие даасан байдлыг нь дэмжиж, эрүүл мэндийн даатгалын тухай хууль, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль, Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулиар иргэд магадлан итгэмжлэгдсэн спортын клубт хичээллэхэд эрүүл мэндийн даатгалаа ашиглах, биеийн тамирыг хөгжүүлэх үйл ажиллагаанд хувийн хэвшлийн оролцоог хангаж, хөрөнгө оруулалт оруулахад төрөөс татварын зохих хөнгөлөлт үзүүлж дэмжихээр зохицуулж хэрэгжээд байна. Ийнхүү бодлого хэрэгжсэнээр биеийн тамир, спортын салбарт төр болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжийн хамтын ажиллагаа сайжирч, иргэд биеийн тамир, спортын арга хэмжээнд хамрагдах хүрээ нэмэгдэж, идэвхтэй хөдөлгөөн, спортоор хичээллэх орчин нөхцөл сайжирч, үндэсний шигшээ багийн тамирчдын бэлтгэл сургуулилтыг шинжлэх ухаан, судалгаа шинжилгээний үндэслэлтэй хийснээр олимп, дэлхийн түвшинд үзүүлэх амжилт нэмэгдэнэ.

ХҮСНЭГТ 1. БИЕЙН ТАМИР, СПОРТЫН БАЙГУУЛЛАГАД АЖИЛЛАГЧИД, бүс, аймаг, нийслэлээр

Аймаг, нийслэл	2016		2017 ¹		2018		2019		2020 ²	
	Бүгд	Эмэгтэй	Бүгд	Эмэгтэй	Бүгд	Эмэгтэй	Бүгд	Эмэгтэй	Бүгд	Эмэгтэй
Бүгд	559	223	5 144	2 240	704	215	737	283	839	317
Баруун бүс	98	33	702	285	107	32	103	39	102	35
Баян-Өлгий	20	6	160	52	18	6	18	6	20	6
Говь-Алтай	18	5	100	39	19	5	19	6	16	6
Завхан	16	6	121	58	17	-	17	6	17	6
Увс	19	8	170	72	28	10	25	10	25	7
Ховд	25	8	151	64	25	11	24	11	24	10
Хангайн бүс	142	62	1 659	711	204	66	167	64	171	67
Архангай	19	9	149	57	20	8	21	7	23	7
Баянхонгор	18	10	129	62	27	13	26	11	30	11
Булган	27	11	107	50	25	12	30	14	28	14
Орхон	30	11	161	84	30	12	28	11	32	13
Өвөрхангай	25	9	111	20	35	11	35	11	35	12
Хөвсгөл	23	12	186	60	67	10	27	10	23	10
Төвийн бүс	126	49	816	378	181	47	172	78	206	86
Говьсүмбэр	17	8	29	14	17	7	17	7	17	7
Дархан-Уул	23	7	233	119	32	12	23	7	23	8
Дорноговь	15	6	82	35	25	12	26	11	47	19
Дундговь	13	4	75	36	15	5	15	5	15	5
Өмнөговь	17	7	123	56	15	6	14	6	23	9
Сэлэнгэ	19	7	152	61	56	-	56	32	56	28
Төв	22	10	122	57	21	5	21	10	25	10
Зүүн бүс	67	26	339	128	63	21	79	33	79	32
Дорнод	18	7	120	46	18	5	18	6	18	5
Сүхбаатар	30	11	97	42	26	9	42	20	42	19
Хэнтий	19	8	122	40	19	7	19	7	19	8
Улаанбаатар	126	53	1 628	738	149	49	216	69	281	97

¹Биеийн тамир, спортын нэг удаагийн үзлэг, тооллогын дүн, ²Биеийн тамир, спортын захиргааны байгууллагад ажиллагчдын тоо болно.

ХҮСНЭГТ 2. БИЕЙН ТАМИР, СПОРТЫН БАЙГУУЛЛАГА, бүс, аймаг, нийслэлээр

Аймаг, нийслэл	2016	2017	2018	2019	2020 ²
Бүгд	31	31	31	31	32
Баруун бүс	5	5	5	5	5
Баян-Өлгий	1	1	1	1	1
Говь-Алтай	1	1	1	1	1
Завхан	1	1	1	1	1
Увс	1	1	1	1	1
Ховд	1	1	1	1	1
Хангайн бүс	6	6	6	6	6
Архангай	1	1	1	1	1
Баянхонгор	1	1	1	1	1
Булган	1	1	1	1	1
Орхон	1	1	1	1	1
Өвөрхангай	1	1	1	1	1
Хөвсгөл	1	1	1	1	1
Төвийн бүс	7	7	7	7	7
Говьсүмбэр	1	1	1	1	1
Дархан-Уул	1	1	1	1	1
Дорноговь	1	1	1	1	1
Дундговь	1	1	1	1	1
Өмнөговь	1	1	1	1	1
Сэлэнгэ	1	1	1	1	1
Төв	1	1	1	1	1
Зүүн бүс	3	3	3	3	3
Дорнод	1	1	1	1	1
Сүхбаатар	1	1	1	1	1
Хэнтий	1	1	1	1	1
Улаанбаатар	10	10	10	10	11

¹Биеийн тамир, спортын нэг удаагийн үзлэг, тооллогын дүн, ²Биеийн тамир, спортын захиргааны байгууллагын тоо болно.

ХҮСНЭГТ 3. БИЕЙН ТАМИР, СПОРТООР ХИЧЭЭЛЛЭДЭГ ТАМИРЧИД, бүс, аймаг, нийслэлээр

Аймаг, нийслэл	2016	2017 ¹	2018 ²	2019	2020
Бүгд	784 733	1 118 400	147 216	152 567	153 308
Баруун бүс	123 370	242 000	30 670	28 404	32 848
Баян-Өлгий	19 417	39 902	9 667	10 695	10 692
Говь-Алтай	31 576	26 670	5 573	643	963
Завхан	13 694	46 457	3 515	9 440	14 900
Увс	19 713	48 838	11 053	6 719	4 240
Ховд	38 970	80 133	862	907	2 053
Хангайн бүс	209 717	268 608	46 212	50 693	36 373
Архангай	11 897	34 861	4 516	3 166	1 675
Баянхонгор	19 950	43 312	9 759	9 976	9 810
Булган	27 178	27 335	3 965	4 759	4 023
Орхон	49 557	48 100	4 351	6 807	5 847
Өвөрхангай	54 479	41 174	7 230	8 565	3 437
Хөвсгөл	46 656	73 826	16 391	17 420	11 581
Төвийн бүс	132 270	176 766	30 172	46 020	49 720
Говьсүмбэр	19 859	13 307	2 748	3 189	594
Дархан-Уул	22 720	19 215	3 690	2 414	1 804
Дорноговь	14 569	16 253	2 937	2 789	3 969
Дундговь	18 636	28 541	13 445	20 299	11 208
Өмнөговь	19 996	23 918	327	455	605
Сэлэнгэ	4 240	28 456	2 241	820	3 160
Төв	32 250	47 076	4 784	16 054	28 380
Зүүн бүс	42 018	107 580	17 257	16 991	11 402
Дорнод	9 432	62 783	6 311	8 304	6 447
Сүхбаатар	11 420	12 335	6 832	3 313	782
Хэнтий	21 166	32 462	4 114	5 374	4 173
Улаанбаатар	277 358	323 446	22 905	10 459	22 965

¹Биеийн тамир, спортын нэг удаагийн үзлэг, тооллогын дүн, ²2018 оноос биеийн тамир, спортоор хичээллэдэг тамирчдын тоогоор авсан.

ХҮСНЭГТ 4. СПОРТ ЗААЛ, бүс, аймаг, нийслэлээр

Аймаг, нийслэл	2016	2017 ¹	2018	2019	2020
Бүгд	850	985	1 000	1 016	1 065
Баруун бүс	154	165	165	167	179
Баян-Өлгий	31	33	33	33	35
Говь-Алтай	28	28	28	28	29
Завхан	30	33	33	33	35
Увс	35	38	38	40	42
Ховд	30	33	33	33	38
Хангайн бүс	204	220	226	233	243
Архангай	34	26	27	28	29
Баянхонгор	31	42	42	42	45
Булган	24	32	32	34	34
Орхон	33	33	33	33	33
Өвөрхангай	37	39	41	44	49
Хөвсгөл	45	48	51	52	53
Төвийн бүс	199	244	247	253	264
Говьсүмбэр	9	10	10	10	10
Дархан-Уул	29	47	47	47	49
Дорноговь	21	29	29	32	32
Дундговь	27	27	28	29	29
Өмнөговь	26	35	35	35	38
Сэлэнгэ	43	45	45	45	48
Төв	44	51	53	55	58
Зүүн бүс	81	84	84	84	89
Дорнод	30	31	31	31	33
Сүхбаатар	16	21	21	21	23
Хэнтий	35	32	32	32	33
Улаанбаатар	212	272	278	279	290

¹Биеийн тамир, спортын нэг удаагийн үзлэг, тооллогын дүн,

ХҮСНЭГТ 5. ЦОЛТОЙ ТАМИРЧИД, ДАСГАЛЖУУЛАГЧИД, ШҮҮГЧИД, бүс, аймаг, нийслэлээр

Аймаг, нийслэл	2020										
	Цолтой тамирчид, дасгалжуулагчид							Цолтой шүүгчид			
	Бүгд	Эмэгтэй	Олон улсын мастер	Спортын мастер	Спортын дэд мастер	Цолтой бөхчүүд	Цолтой сурын харваачид	Бүгд	Эмэгтэй	Олон улсын шүүгч	Улсын шүүгч
Бүгд											
Баруун бүс	371	78	28	168	85	56	34	8	1	-	8
Баян-Өлгий	50	5	3	16	12	8	11	1	-	-	1
Говь-Алтай	86	19	11	36	14	11	14	-	-	-	-
Завхан	79	10	5	42	15	16	1	3	-	-	3
Увс	82	21	7	38	23	11	3	3	-	-	3
Ховд	74	23	2	36	21	10	5	1	1	-	1
Хангайн бүс	449	105	39	167	151	64	28	13	-	-	13
Архангай	122	23	5	47	49	15	6	7	-	-	7
Баянхонгор	73	29	4	27	25	11	6	-	-	-	-
Булган	59	8	9	16	19	10	5	3	-	-	3
Орхон	61	18	10	35	10	1	5	-	-	-	-
Өвөрхангай	90	20	5	28	39	15	3	2	-	-	2
Хөвсгөл	44	7	6	14	9	12	3	1	-	-	1
Төвийн бүс	425	113	19	181	126	60	39	13	1	-	13
Говьсүмбэр	21	4	-	2	11	5	3	-	-	-	-
Дархан-Уул	63	21	5	28	21	4	5	2	1	-	2
Дорноговь	58	18	-	22	19	9	8	2	-	-	2
Дундговь	53	12	-	27	8	9	9	-	-	-	-
Өмнөговь	59	18	-	26	19	9	5	1	-	-	1
Сэлэнгэ	102	24	4	47	37	10	4	7	-	-	7
Төв	69	16	10	29	11	14	5	1	-	-	1
Зүүн бүс	214	50	28	91	60	23	12	13	3	-	13
Дорнод	86	20	15	40	19	6	6	1	-	-	1
Сүхбаатар	44	9	-	11	18	12	3	4	1	-	4
Хэнтий	84	21	13	40	23	5	3	8	2	-	8
Улаанбаатар	209	37	30	93	61	4	21	23	8	5	18